



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠲᠤᠭᠤᠨ ᠠᠯᠠᠭᠤᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠲᠤᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/267

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Тонхил сумын нутаг дэвсгэрт хийгдсэн ГАА/ОНӨГ202203065 дугаар гэрээт хорооллын гадна цахилгааны дэд өртөө, шугам сүлжээний угсралтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

- Комиссын дарга: Б.Бямбадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор)
- Гишүүдэд: М.Мандаххүү (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)
- Д.Отгонжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
- З.Жаргалтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн)
- Б.Лхагва-Очир (Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)
- Ц.Амарсанаа (Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)
- Б.Балдорж (Орон нутгийн өмчийн газрын хадгалалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн)
- Б.Бээжин ("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал бөгөөд ерөнхий инженер)

2.

М.Насанбат (Тонхил сумын Засаг дарга)
(тохиролцсоноор)

Б.Оюунболд ("Ди Ди Эй Жи" ХХК-ийн инженер,
зохиогч)

М.Бямбажав ("Сутайн гэрэл" ХХК-ийн захирал,
гүйцэтгэгч)


Нарийн бичгийн дарга: М.Мөнхцэцэг (Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын инженерийн
байгууламж хариуцсан мэргэжилтэн)

2.Цахилгааны дэд өртөө, шугам сүлжээний угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа ажил гүйцэтгэх гэрээ, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Холбогдох акт, баримт бичгийг үндэслэн орон нутгийн өмчид бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), барилга байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгаж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Тонхил сумын Засаг дарга (М.Насанбат)-д тус тус даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/726 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ